

Сургууль, багшийн үйл ажиллагааг дэмжихэд орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо

/Орхон аймагт хэрэгжиж буй “Багш” дэд хөтөлбөрийн жишээгээр/

О.Нандин-Эрдэнэ, Д.Өлзийлхагва,
МУИС-ийн Эрдэнэт сургууль*

Хураангуй

Боловсролыг нийгмийн үйлчилгээний нэгэн төрөл гэж үзэн түүний хувь хүний болоод нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн зорилго, үр дүнгийн шалгуурыг өнөөгийн хүмүүнлэг, ардчилсан нийгэм дэх төр-нийгмийн үйлчилгээтэй холбон судлах зайлшгүй хэрэгцээ байна. Иймээс бид Орхон аймгийн засаг даргын тамгын газраас тухайн орон нутгийн боловсролын салбарт авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг Орхон аймгийн боловсролын байгууллагаас авсан судалгаан дээр үндэслэж хийсэн болно. Үүний тулд

- Тус хөтөлбөрийн 2017 болон 2018 жилийн хугацаанд хэрэгжсэн ажлын харьцуулалт түүний үр дүнг боловсруулах
- Багш дэд хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээний асуулгын үр дүнг энэхүү өгүүлэлд авч үзсэн болно. Бид “Багш” дэд хөтөлбөрийн:
 1. Багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах
 2. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх
 3. Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилтууд 2017, 2018 онд хэрхэн хэрэгжсэнийг он тус бүрээр авч үзэж, харьцуулалт хийн үр дүнг боловсруулж үзэхэд дээрх зорилт бүрээр хийгдсэн ажлууд тодорхой үр дүнд хүрснийг харуулсан. Дараагийн судалгаанд тус хөтөлбөрийн хүрээнд сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээний асуулга боловсруулж ажилладаг салбар, эрхэлж буй албан тушаал, боловсролын байгууллагад ажилласан жил, багш дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа авч үр дүнг тооцсон болно. Цаашид тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй арга хэмжээ тус бүрээр санал асуулга авч тухайн боловсролын байгууллагын шат шатанд тохирсон арга хэмжээг зохион байгуулах, тэдний саналыг тусгаж, хэлэлцүүлэг хийж, орон нутгийн болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах шаардлага байна. Энэ нь боловсролын байгууллагын нэр хүндийг олон нийтийн дунд өсгөхөөс гадна Багш дэд хөтөлбөрийн цаашдын төлөвлөгөөнд хувь нэмэр оруулах ажил болох юм.

Түлхүүр үг

Төсөл хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, боловсрол

Боловсролыг нийгмийн үйлчилгээний нэгэн төрөл гэж үзэн түүний хувь хүний болоод нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн зорилго, үр дүнгийн шалгуурыг өнөөгийн хүмүүнлэг, ардчилсан нийгэм дэх төр-нийгмийн үйлчилгээтэй холбон судлах зайлшгүй хэрэгцээ байгаа билээ. Орхон аймгийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, аймгийн засаг даргын тамгын газар орон нутгийн боловсролын салбарт тодорхой төлөвлөгөөний дагуу дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Орхон аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр
2. Багшийн хөгжил хөтөлбөр
3. Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын чанарын шинэчлэл хөтөлбөр
4. Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн

парк байгуулах төсөл

5. “Багш” дэд хөтөлбөр

Дээрхээс бид энэ өгүүллийн хүрээнд Орхон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Багш” дэд хөтөлбөр нь Монгол улсын болон орон нутгийн боловсролын салбарт баримталж буй ойрын болон хэтийн бодлоготой хэрхэн уялдаж байгаа, “Багш” хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл явц, хэрэгжилт, үр дүнг сургууль, багшийн үйл ажиллагааг дэмжихэд бодит үр нөлөө гарсан эсэхийг судалсан болно. Үүний тулд

1. Тус хөтөлбөрийн 2017 болон 2018 жилийн хугацаанд хэрэгжсэн ажлын харьцуулалт түүний үр дүнг боловсруулах
2. Багш дэд хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээний

асуулгын үр дүнг энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

“Багш” дэд хөтөлбөр нь боловсролын салбарын багш, ажилтнуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр бөгөөд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Бүсчилсэн хөгжлийн бодлого, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он), Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхонаймгийн хөгжлийн цогц бодлого, Орхон аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүх шатны боловсролын багш, удирдах ажилтан, ахмад багш, эрдэмтдийн саналд үндэслэн боловсруулсан байна.

Тус хөтөлбөр 4 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд

тайлагнадаг. “Багш” дэд хөтөлбөрийн зорилго нь **салбарын** багш, ажилтны хөгжлийг дэмжих, таатай нөхцөл бүрдүүлэх, тэдний нэр хүнд, нийгмийн баталгааг нь хангах, хүний хөгжил, боловсролын байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино. Хөтөлбөрийн зорилтыг дараах байдлаар дэвшүүлжээ. Үүнд:

1. Багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах
2. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх
3. Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах гэж тусгасан байна.

Дээрх зорилтуудын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дараах хүснэгтээр он тус бүрээр харуулав.

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2017	2018	Хамрах хүрээ
1	Багш ажилтныг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах	40 дээш насны 1469/977 хүн 20.0 сая/29.3 сая	30-40 насны 867/310 хүн 20.0 сая/20.0 сая	СӨББ, ЕБС МСҮТ, ИДС
2	AR кабинет байгуулах	5 сургууль Нэг бүр нь 3.5 сая 11.0 сая/17.5 сая	11 сургууль 30,0 сая/29.4 сая төг	ЕБС
3	Кабинетын орчин нөхцөл сайжруулах	1 цэцэрлэгт кабинет байгуулсан /5 кабинет, 6 байгууллага/ 10.0/5.2 сая	5 сургууль, 11/5 төсөл шалгарсан	СӨББ ЕБС
4	Багш хөгжлийн төв байгуулах	-	3 төв байгуулсан 2.0/ 1.2 сая	СӨББ ЕБС

Дээрх хүснэгтэд Багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах 1-р зорилтын хүрээнд 2017 онд 3 арга хэмжээ, 2018 онд 4 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Дээрх арга хэмжээнүүдийн биелэлт он оныхоо төлөвлөгөөний дагуу 100 хувь биелсэн боловч хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байна. Ялангуяа багшийн ажиллах орчин

нөхцөлийг сайжруулах тал дээр зохион байгуулсан арга хэмжээнд МСҮТ болон орон нутгийн их дээд сургуулиудыг хамруулаагүй байна.

Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх 2-р зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дараах хүснэгтээр он тус бүрээр харуулав.

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2017	2018	Хамрах хүрээ
1	Их дээд сургуулийг түшиглэн багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт	Англи хэл 24 багш Орос хэл 23 багш 3.5 сая/3.5 сая	Англи хэл анхан шат 27 Дунд шат 24 багш 4.0/4.0	С О Б Б ЕБС МСҮТ
2	Нийгмийн ажилтны сургалт	16 хүн 24 цагийн сургалт МУБИС 2.5 сая/2.3 сая	-	ЕБС
3	Захиалгат сургалт	820 багш 5 судлагдахуун 5.0 сая/4.7 сая	250 багш 5 судлагдахуун -	С О Б Б ЕБС
4	Модуль сургалт /хөтөлбөр боловсруулах/	100 залуу багш 1 арга хэмжээ 5.0 сая/2.0 сая	100 залуу багш 2, 3 арга хэмжээ 10.0 сая/10.0 сая	С О Б Б ЕБС МСҮТ

5	Багш солилцоо хөтөлбөр	Гадаадад 14 багш Дотоодод 8 багш 15.0/11.2 сая	Гадаадаас ирсэн 2 Дотоодод 59 багш	С Ө Б Б ЕБС
6	Зөвлөх үйлчилгээ	Зөвлөх зэрэгтэй багш нарын баг байгуулж мэргэжлийн багш нарыг дагалдуулан ажилласан.	Зөвлөх 20 багш нар үзүүлэх хичээл заасан 80 гаруй багш хамрагдсан	ЕБС
7	Залуу багш нарын чуулга уулзалт	1-5 жил ажилласан багш нарыг хамруулсан 2.0 сая/1.9 сая	-	ЕБС
8	Судлаач багш, ажилтан	250 багш 3.0/2.6 сая	180 багш 3.0/3.0 сая	СӨББ, ЕБС, МСҮТ, НТБТ
9	Сайн арга зүйч, сайн үйл ажиллагаа	-	308 багшийг хамруулж 27 бүтээлийг шалгаруулж цахим санд байршуулсан 3.0/3.0 сая	С Ө Б Б ЕБС
10	5s хөтөлбөр хэрэгжүүлсэн Ажлын байрны бүтээмж аян	-	5 байгууллагад бүтээмж чанарын дугуйлан хичээллүүлж эхэлсэн	С Ө Б Б ЕБС

Дээрх хүснэгтээс үзэхэд 2017 онд нийт 8, 2018 онд нийт 9 үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Цогц байдлаар зохион байгуулсан тогтмол үйл ажиллагаа 50 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн үйл ажиллагаа тогтмолжиж үр дүнтэй болох сайн талтай юм. Үйл ажиллагааны биелэлтийг нэгдсэн төлөвлөгөө тайлантай харьцуулан үзэхэд 70-100 хувиар хэрэгжсэн байна. Зарим арга хэмжээг дараа дараагийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай болох нь харагдаж байна. Хамрах хүрээний хувьд МСҮТ цөөн арга хэмжээнд оролцож харин орон нутгийн их дээд сургуулиудыг хамруулаагүй байна. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх тал дээр бүх шатны боловсролын байгууллагыг шат дараатайгаар оролцуулан дэмжих нь зүйтэй юм.

Зохион байгуулсан үйл ажиллагааны ач холбогдлыг зарим ажилд тодорхой тусгаагүй

байна. Иймд дараа дараагийн төлөвлөгөөний дагуу зохиогдох арга хэмжээнд бодит үр дүн гарсан эсэхийг зайлшгүй тусгаж, судалгаа авч үр дүнг харуулдаг байх шаардлагатай байна. Цаашид бодит үр дүн гарч байгаа сургалт, багш ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа арга хэмжээнүүдийг тогтмолжуулж, хамрах хүрээг өргөжүүлж ажиллах нь үр дүнтэй юм. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс тодорхой хөрөнгө төсөвлөн зарцуулж байгаа нь сайшаалтай боловч бодит үр дүнд хүрч байгаа арга хэмжээнд түлхүү хуваарилах нь зүйтэй.

Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах гэсэн 3 дахь зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2017	2018	Х а м р а х хүрээ
1	Нийгмийн дэмжлэгийн сан	Журам боловсруулах 230 гаруй материалаас 37 хүнд 300-700 мянга төг 30.0/18.5 сая	Багш хөгжлийн Дэмжих сан 78 ажилтанд 35 сая төгрөгийн дэмжлэг 35.0/35.0 сая	С Ө Б Б ЕБС БСУГ
2	Сургалтын чанар, ажлын үр дүнг үзүүлэлтээр дүгнэх	Журам боловсруулсан Мэргэжлийн аварга багш шалгаруулсан 10 багш 10.0 сая/6.680	Мэргэжлийн аварга багш шалгаруулсан 13 багш	СӨББ ЕБС МСҮТ
3	Секц, дугуйлан амжилттай удирдаж байгаа багш шалгаруулах	29 багшийн 62 бүтээлээр үзэсгэлэн гаргасан 3.0 сая/1.5 сая	Спортын, мэргэжлийн аварга багш, Тэргүүний үйл ажиллагаатай байгууллага Номинацид 7.0 сая/7.0 сая	СӨББ ЕБС

Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах тал дээр гурван үйл ажиллагаа явуулсан байна. Үүнээс багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдэх зориулалтаар нийгмийн дэмжлэгийн сангаар дамжуулан орон байрны нөхцөлөө сайжруулах, оюутны сургалтын төлбөрт дэмжлэг авах, дотоод, гадаадад эмчилгээнд явахад тодорхой хувиар дэмжлэг үзүүлсэн байна. Мэргэжлийн ур чадвар болон спортын амжилт гаргасан багш нарын нэр хүндийг өсгөж мөнгөн урамшуулал олгожээ.

Дараагийн судалгаанд тус хөтөлбөрийн хүрээнд сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээний асуулга боловсруулан авахад

Орхон аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагад 1741 багш ажиллагсаас судалгаанд 426 багш хамрагдсан байна.

1. Судалгаанд оролцогчдын ажилладаг салбарын хувьд авч үзвэл:



Дээрх графикаас үзэхэд судалгаанд оролцогчдын 59% нь ЕБС, 24% СӨББ, 10% ИДС, 4% МСҮТ, 3% БСУ-ын салбарт ажиллаж байна. Үүнийг статистик дүн мэдээтэй харьцуулахад Орхон аймгийн боловсролын шат шатны байгууллагаас 30 орчим хувийг хамруулсан нь харагдаж байна.

2. Судалгаанд оролцогчдыг эрхэлж буй албан тушаалын хувьд авч үзэхэд удирдах ажилтан-40, багш 372, үйлчилгээний ажилтан оролцоогүй, бусад 14 хүн байв. Бидний судалгаанд дийлэнх 87 хувийг багш нар эзэлсэн байна.



Судалгаанд оролцсон багш ажилтны боловсролын салбарт ажилласан жилийг авч үзвэл:

- 1-5 жил ажилласан 46 багш, ажилтан
- 6-11 жил ажилласан 93 багш, ажилтан
- 12-18 жил ажилласан 198 багш, ажилтан
- 19-25 жил ажилласан 67 багш, ажилтан
- 26-аас дээш жил ажилласан 22 багш, ажилтан байна.

Үүнээс үзвэл боловсролын салбарт 12-18 жил ажилласан багш ажилтан дийлэнх хувийг буюу 45,5 хувийг эзэлсэн байгаа нь тухайн салбартаа туршлагажсан гэж үзэж болох юм. 1-5 жил ажилласан багш, ажилтан хамгийн бага хувийг эзэлж байна.

4. “Багш” дэд хөтөлбөрийн талаар хэн сайн мэддэг вэ гэсэн асуултад

- Сайн мэддэг-16 багш
- Мэддэг-211
- Мэддэг боловч хамрагдаагүй-70
- Мэдэхгүй-16

Дээрхээс үзвэл “багш” дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчдын 96 хувь нь мэдээлэлтэй байна.

5. Та багш дэд хөтөлбөрт хамрагдсан уу гэсэн асуултад

- Тийм- 240
- Үгүй- 186

Дээрх хариултаас үзвэл судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь ямар нэгэн байдлаар уг хөтөлбөрт хамрагдсан байна.

6. Та багш дэд хөтөлбөрийн 2018 оны биелэлтийн тайлангаар танилцсан уу

- Тийм -194
- Үгүй -232

Хөтөлбөрийн тайлангийн биелэлтийг дэлгэрэнгүй танилцуулах шаардлага байгаа нь харагдаж байна. Үүний тулд боловсролын бүх шатны байгууллага бүрд үр дүнгийн биелэлтийг хэвлэн тарааж удирдлага нь багш ажилтан нэг бүрд танилцуулж гарын үсэг зуруулж, санал хүсэлтийг авах нь зүйтэй юм.

7. Та багш дэд хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийн биелэлтэд хэр сэтгэл ханамжтай байгаагаа үнэлнэ үү гэсэн асуултад хариулсан байдлыг дараах графикаар харуулав.



Багш ажилтны эрүүл мэндийг хамгаалах, 72% Багш ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх 74%, Багш хүний нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах 53% байгаа нь тус хөтөлбөрийн зорилтуудыг сайн гэж үнэлсэн болохыг харуулж байна. Энэ нь тус хөтөлбөр 2 жилийн хугацаанд хангалттай сайн хэрэгжиж байгааг харуулж байна.

8. Хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтээс хамгийн үр дүнтэй хэрэгжсэн 5 арга хэмжээг нэрлэнэ үү

- Сайн багш хөтөлбөр -176
- Кабинетын орчин нөхцөл сайжруулах -104
- Эрүүл мэндийн үзлэг оношилгоо- 89
- 100 залуу багш - 87
- Судлаач багш -59
- Багш солилцоо хөтөлбөр - 58

Дээрх асуулгад судалгаанд оролцсон багш нарын саналыг нэгтгэн багцлан ангилж үзэхэд дээрх саналууд хамгийн их давтамжтай байв. Хөтөлбөрийн хүрээнд нийт 18 арга хэмжээ явуулснаас дээрх арга хэмжээнүүд 50-аас дээш хүний санал авсан байна.

9. Та багш дэд хөтөлбөрт хамрагдсан бол таны мэргэжил бусад зүйлд хэрхэн нөлөөлсөн талаар товч дурдана уу гэсэн судалгаанд хамрагдсан багш нарын саналыг нэгтгэж үзвэл

- Шинэ санаа, шинэ арга туршлагыг хичээл сургалтдаа ашигласан- 62%
- Ахмад болон зөвлөх багш нараас суралцах боломж нэмэгдсэн -42%
- Багш нарын ажиллах таатай орчныг бүрдүүлсэн - 40%
- Судалгаа шинжилгээний ажил хийх идэвх нэмэгдсэн - 34%
- Гадаад хэлний мэдлэгээ нэмэгдүүлсэн -30%

Дээрхээс үзвэл тус хөтөлбөрийн ач холбогдол, үр дүнг илэрхийлсэн дээрх хариултууд дийлэнх хувьтай байна.

10. Багш дэд хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаанд тусгах саналаа бичнэ үү гэсэн асуултад дараах саналуудыг дурдсан байна. Үүнийг боловсролын байгууллагын шат бүрээр авч үзэн нэгтгэснийг доорх хүснэгтээр харуулсан болно.

№	Оролцогч	Тоо	Санал тусгах /Эрэмбэлсэн байдлаар/
1	БСУГ	12	1. Багшийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого 2. Багшийн бүтээлийг үнэлэх, ашиглан индексжүүлэх 3. Эрдэнэт үйлдвэртэй хамтарья, санхүүгийн дэмжлэг авъя. Ажилтны олон хүүхэд сурч хүмүүжиж байна. Нийгмийн хариуцлагын дэмжлэг байх шаардлагатай 4. Их, дээд сургууль, МСҮТ, ЕБС салангид үйл ажиллагааг нэгтгэх 5. Эрдэмтдийн зөвлөлд ЕБС, СӨББ-ын зөвлөх зэрэгтэй багшийн оруулах
2	СӨББ-ын удирдах ажилтан СӨББ-ын багш	102	1. Залуу багш нарыг орон сууцжуулах, түрээсийн орон сууцанд хамруулах 2. Аймагт “Багшийн хөгжлийн ордон” байгуулах 3. Интернетийн хурдыг нэмэгдүүлэх 4. Ахмад, залуу багш нарын залгамж холбоо арга хэмжээг зохион байгуулах 5. Залуу багш нарын клуб байгуулах, хөгжлийн цагтай болох
3	ЕБС-ийн удирдлага, багш	18	1. Түрээсийн орон сууц, орон сууцжуулах хөтөлбөрт багш нарыг ямар нэгэн хэлбэрээр хамруулах 2. Эдийн засгийн урамшууллыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах 3. Анги танхимын хүртээмжийг нэмэгдүүлэх 4. Анги удирддаг багш илүү хариуцлагатай, нэмэлт үйл ажиллагаа ихтэй учир нэмэгдэл хөлсийг уян хатан олгох асуудлыг шийдвэрлэх 5. Багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх
		147	Дунд ангийн багш нарын санал 1. Солонгос, Япон улсын боловсролын байгууллагын үйл ажиллагаанаас туршлага судлах зорилгоор багш нарыг сонгон шалгаруулж зардлыг шийдвэрлэн үр дүнтэй хамруулах 2. Бүс, аймгийн масс олимпиадыг зохион байгуулахад зардал, шагналын санд хөрөнгө оруулалт хийж өгч дэмжих 3. Багш нарын санаачилсан төслийг сонгон шалгаруулж зардал мөнгийг нь санхүүжүүлэн дэмжихэд туслах 4. Багш ажилчдын цалинг нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж уламжлах 5. Багш нарын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор орон нутгийн үйл ажиллагаа нь жигдэрсэн рашаан сувиллын газартай гэрээ байгуулан хөнгөлөлттэй үнээр багш нарын хамруулан дэмжлэг үзүүлэх
		86	Бага ангийн багш нарын санал 7. Зуны амралтын хугацаанд ажил эрхлэх сонирхолтой багш нарт дэмжлэг үзүүлэх /бага хүүтэй мөнгө зээлэх боломж/ 8. Алслагдсан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэгт амжилттай сайн ажиллаж байгаа багш нарт тэтгэмжийг жил бүр олгож байх 9. Бага ангид сонгон секц амжилттай хэрэгжүүлсэн багшид мөн урамшуулал олгох

4	Их, дээд сургууль, Эрдэмтдийн зөвлөл	42	1. Инноваци – шинэ санаа арга хэмжээ зохион байгуулах 2. Боловсролын инновацийг төслөөр шалгаруулж авах 3. Орон нутгаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт багш нарыг хамруулах
5	МСҮТ	19	1. Статус, үйл ажиллагааныхаа чиглэлээр тодорхойгүй асуудлууд байна. 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг хөгжүүлэхэд МСҮТ-ийн багшийг бүрэн хамруулж байх 3. Орон сууцны хөнгөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх 4. Уралдаан, тэмцээн, чадваржуулах ажилд татан оролцуулж байх 5. Хөдөлмөрийн үнэлэмжийг оновчтой болгох

Дээрх саналуудыг мөн эрэмбэлсэн байдлаар, давтамжаар нь оруулсан. Энэхүү саналуудыг Багш дэд хөтөлбөрийн 2019 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлж байна.

Дүгнэлт

Орхон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй Багш дэд хөтөлбөр нь хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд бүх шатны боловсролын байгууллагад ажиллаж буй багш ажилтнуудаас авсан саналын үр дүнд хэрэгжиж буйгаараа хүртээмжтэй, ач холбогдолтой арга хэмжээ болсон боловч хамрах хүрээний хувьд орон нутгийн их, дээд 3 сургууль болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 2 сургуулиуд төдийлөн сайн хамрагддаггүй байна.

Хөтөлбөрийн саналуудыг үндэслэн гурван зорилт болгон багцалж зорилт бүрээр хийх арга хэмжээнүүдийг он оны төлөвлөгөөнд тусган ажилладгаараа онцлог давуу талтай. Мөн яам, орон нутгийн төсөв, гадаад болон орон нутагт хэрэгжиж буй төслийн шугамаар санхүүжүүлэн хэрэгжиж байгаагаараа онцлог юм.

Хөтөлбөрийн зорилт бүрээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны биелэлт 70-аас дээш хувьтай байгаа нь хөтөлбөрийн биелэлт үр дүн сайн хэрэгжиж байгаа гэж үзэж болно. Биелэлтийн үр дүнг хангахын тулд дараагийн төлөвлөгөөнд тусгаж үргэлжлүүлэн хэрэгжүүлдэг нь сайшаалтай юм.

Багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах гэсэн гурван зорилтоос “Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах” гэсэн гуравдугаар зорилт багш нараас авсан сэтгэл ханамжийн судалгаанаас үзвэл 50-аас дээш хувь нь тааруу үнэлгээтэй байгаа нь уг зорилтын хүрээнд хийгдэж буй ажлууд төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй

арга хэмжээ тус бүрээр санал асуулга авч тухайн боловсролын байгууллагын шат шатанд тохирсон арга хэмжээг зохион байгуулах, тэдний саналыг тусгаж, хэлэлцүүлэг хийж, орон нутгийн болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах шаардлага байна. Энэ нь боловсролын байгууллагын нэр хүндийг олон нийтийн дунд өсгөх арга хэмжээ болох юм.

Хөтөлбөрт тусгах саналуудыг алийг нь хэрэгжүүлж байгаа алийг нь орхигдуулж байгааг боловсролын байгууллагын удирдлагуудад танилцуулдаг байх, хөтөлбөрт хамрагдах багш нарын судалгааг гарган үйл ажиллагаанд тэгш оролцуулдаг байх, тэргүүний багш нарын туршлагыг аймаг, бүс, улсын хэмжээнд түгээх арга хэмжээг өргөжүүлэх шаардлага байна.

Ном зүй

Орхон аймгийн засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Орхон аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр

“Багш” дэд хөтөлбөрийн 2017 оны төлөвлөгөө

“Багш” дэд хөтөлбөрийн 2017 оны тайлан

“Багш” дэд хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө

Багш” дэд хөтөлбөрийн 2018 оны тайлан

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2014-2024 он, <https://www.legalinfo.mn/annex/details/6661?lawid=10935>

МУ-ын боловсролын тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/9020>

**Involvement of local self-governing organizations to support
activities of schools and teachers**
(for example the implementation of "teacher" sub program in Orkhon aimag)

*Nandin-Erdene.O, Ulziilkhagva.D,
Erdenet School of NUM*

Abstract

There is a need to study education as a social service, and to evaluate the purpose and effectiveness of its impact on individual and social development in relation to public-service in today's humanitarian and democratic societies. Therefore, we have conducted our research on educational institutions and organizations in the local education sector and their implementation and results which was organized by governor's office of Orkhon province. The following issues are discussed in this article. 1. Comparison of implementation of the project done during the 2017 and 2018 years of the program and its outcomes. 2. The survey and evaluation questions of the sub-program In our research work "Teacher" sub program has three objectives. Such as: 1. To improve teachers' and staff's health and working environment and condition. 2. To improve their knowledge, education and skills. 3. To improve teachers' reputation and values and set goals for social welfare. We compared the results and outcomes to show the results of above each objectives and the project have been achieved tangible results. In the next survey, we conducted a survey on the satisfaction and evaluation questionnaires, their positions, duration of the position, and the implementation of the sub-program. It is necessary to conduct a questionnaire for each of the activities which were implemented in the sub program and to organize events that are appropriate to the stage of the educational institution, to reflect on their proposals, to discuss and to advertise through local and other media. This will be the way to increase the reputation of education institutions in the community.

Keywords

Projects and programs, their implementation, outcomes, education
